



БАЯНГОЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ-д

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 120
танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аudit MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аudit MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030833

D:\Auditiiin gazar\baiguullagiin dotood barimt\A4


Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Сумын Монгол Ардын Намын хорооны
2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 03 тогтоолын
Хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН МАН-ААС 2020 ОНЫ СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Эрхэм зорилго: Монгол улсын тэргүүний /загвар/ сум болох
Хөтөлбөрийн нэр: Өрхийн хөгжил-Хөгжлийн үндэс
Зорилтууд:

1. Хүний хөгжил буюу нийгмийн салбар

- 1.1. "Баянголынхон" өрх, гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.2. Иргэдэд үйлчлэх /соён гэгээрүүлэх/ албан бус сургалтын явуулын үйлчилгээг бий болгоно.
- 1.3. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.4. Соёлын төвийн дэргэд "Залуус хөгжлийн төв" байгуулж, үйл ажиллагааг нь дэмжиж ажиллана.
- 1.5. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгчдийн тоог 90-аас дээш хувь, сайн дурын нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдийн тоог одоогийнхоос 20 хувиар өсгөж, төрөөс ашиг хүртэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

2. Эдийн засгийн салбар

- 2.1. Татвар төлөгчдийн хүрээг өргөтгөж, сумын төсвийг орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.2. Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийн зарцуулалт, тендер, худалдан авах ажиллагаанд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

3. Байгаль орчин, газар зохион байгуулалт

- 3.1. "Ногоон сум" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ногоон байгууламжийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 3.2. Сумын баруун хойд талд 2000 м элсний нүүдлээс хамгаалах ойн зурvas байгуулна.
- 3.3. Байгаль орчин, бэлчээрт сөргөөр нөлөөлж байгаа мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулна.
- 3.4. Сумаараа хоггүй цэвэр байх зорилтыг үргэлжлүүлж хэрэгжүүлнэ.
- 3.5. Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг шат дараатай хийнэ.
- 3.6. Сумын төвд хурсан элсийг зөөж, ахуйн хайрга ашигласан газруудад нөхөн сэргээлт хийнэ.

4. Дэд бүтэц, аялал жуулчлал

- 4.1. Арвайхээрээс-Баянгол-Сайхан овоо- Цогтоо овоо- сумдыг холбосон аялал жуулчлал, бизнесийн хатуу хучилттай автозам тавих ажлыг эхлүүлэх,
- 4.2. Сумын төвд 2 км хатуу хучилттай автозам тавих,
- 4.3. Цэвэрлэх байгууламжийн инженерийн шугамын өргөтгөл хийж, айл өрх, ААН-ийг ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.4. Цахилгааны шугамын дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, 04-ийн шугмын өргөтгөлийг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан хийнэ.
- 4.5. Сумын үзэсгэлэнт газар, рашаан сувилалыг түшиглэсэн амралт, сувилал, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримталж, дэмжиж ажиллана.
- 4.6. Түүхт "Пур ширээ" хайрханыг тохижуулах ажлыг иргэдтэй хамтран хийнэ.

- 4.7. Бандида ламтны дөтгөөр дүр буюу олноо “Догшин дүр” хэмээн алдаршсан Лувсанжалданняндагийн мэндэлсэн газрыг тохижуулах.
- 4.8. Төв замын дагуу тэмдэг тэмдэглэгээ хийнэ.
- 4.9. Сумын /хойд/ өндөрлөгийг тохижуулна.
- 4.10. Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камерын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 4.11. Эргэндэнж багт “Онги гол” дээгүүр мотоциклийн гүүр барина.
- 4.12. Үүрэн телефоны сүлжээ, интернетийн хурдыг нэмэгдүүлнэ.
- 4.13. Хот /сум/ хооронд зорчих нийтийн тээврийн маршрутыг гаргаж, гүйцэтгэгчийг сонгон, иргэдийг баталгаатай тээврийн хэрэгслээр зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

5. ХАА-н салбар

- 5.1. Мал аж ахуйг бэлчээрийн даацад тулгуурлан эрсдэлгүй, эдийн засгийн үр ашигтайгаар эрхлэх бодлого баримтална.
- 5.2. Малыг зэмэгжүүлэн бүртгэлжүүлж, эрүүлжүүлэх, зах зээлд /экспорт/ давуу эрхтэйгээр нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 5.3. “Баянгол омог”-ийн хонин сүргийг “Баянгол үүлдэр” болох 10 жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 5.4. “Баянгол омог”-ийн хоньтой болон уг омгоор хониор сайжруулсан хоньтой малчид, иргэдийн ноосны урамшууллыг нэг хонины 1,4 кг ноосоор тооцож олгодог болно.
- 5.5. Бэлчээр усжуулалтын ажлыг үргэлжлүүлж хийнэ.
- 5.6. Сумын аюулгүйн нөөцийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, нөөц /өвс, тэжээл/ бүрдүүлж ажиллана.
- 5.7. Мал эмнэлэгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 5.8. Газар тариалан эрхлэгчдийг дэмжиж, сумын хэрэглээний 70-аас доошгүй хувийг суманд тарьсан төмс, хүнсний ногоогоор хангадаг болно.
- 5.9. Малын тэжээлийн ургамал, жимс жимсгэнэ тариалагчдыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 5.10. Баг бүрийг мал угаалгын ваннтай болгоно.

6. Боловсролын салбар

- 6.1. ЕБС-ийн 320 хүүхдийн хичээлийн байрны их засварыг хийнэ.
- 6.2. 320 хүүхдийн хичээлийн байранд урлаг заал бүхий өргөтгөл хийж анги танхимиyg нэмэгдүүлнэ.
- 6.3. Багш, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулах замаар сурагчдын сургалтын чанарт ахиц гаргана.
- 6.4. ЕБС-ийн хуучин спорт заалыг засварлаж спортын бэлтгэлийн заалаар ашиглана.
- 6.5. Цэцэрлэгийн барилгын их засвар хийнэ.
- 6.6. Цэцэрлэгт урлаг заалыг шинээр барина.
- 6.7. Амжилт гаргаж буй багш, ажилчдыг урамшуулдаг журмыг өөрчилж, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.
- 6.8. Соёлын төвийн барилгыг ашиглалтанд оруулж, соёл олон нийтийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор бүрэн хангана.
- 6.9. Суманд соёлын байгууллага үүсч хөгжсөний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.

- 6.10. Орон нутгийн судлах танхимыг соёлын төвийн дэргэд байгуулж, сумын түүх, үзмэрийг баяжуулж ажиллана.
- 6.11. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх орчин бүрдүүлнэ.
- 6.12. Сумын спорт заалны гадна талыг хайсжуулж, авто зогсоолтой болгоно.
- 6.13. Багш, ажилчдын байрыг хайсжуулж, тохижуулна.

7. Эрүүл мэндийн салбар

- 7.1. Эрүүл мэндийн төвийг дутагдалтай байгаа хүний нөөцөөр бүрэн хангана.
- 7.2. Уламжлалтын эмнэлэгтэй болж, ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 7.3. Иргэдэд эрүүл аж төрөх, хандлагыг олгож, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.
- 7.4. Сумын нутаг дэвсгэрт амралт, сувиал байгуулах ААН, иргэдийг дэмжиж ажиллана.

8. Үйлдвэрлэл, үйлчилгээ

- 8.1. Эсгий, ноосны үйлдвэрийг өргөжүүлж бүх төрлийн малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах боломжийг бий болгоно.
- 8.2. Орон нутгийн нөөцөд түшиглэсэн мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгч иргэд, ААН-ийг дэмжиж хамтарч ажиллана.
- 8.3. Улаан нуурын элсний ордыг эдийн засгийн хувьд суманд ашигтай байх нөхцөлөөр ашиглуулна.
- 8.4. Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг өрсөлдөөний зарчмаар ашиглах боломжийг олгож санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжиж хамтарч ажиллана.
- 8.5. Суманд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, шилдэг бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд нийлүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- 8.6. Сумын бизнес хөгжлийн төвийн барилгыг засварлаж ажиллах нөхцөлийг сайжруулна.
- 8.7. Хувийн хэвшлийг дэмжих замаар нийтийн халуун ус, машин угаалгын газартай болно.

9. Нутгийн удирдлага

- 9.1. Иргэдийн эрх, үүргийн нэгдлийг хангах, соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулна.
- 9.2. Сумын ЗДТГ-ын барилгын өргөтгөл хийж, их засварт оруулна.
- 9.3. Суманд нэгдсэн багийн төвийг шинээр бий болгоно.
- 9.4. Сумын бренд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ.
- 9.5. Хувийн хэвшлийг дэмжих замаар хувийн орон сууцны тоог нэмэгдүүлнэ.
- 9.6. Сумын түүхт 100 жилийн ой утгаж ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.
- 9.7. Сум тохижилт үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж, бие даан ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 9.8. Зарим багуудын төвийг засварлаж, тохижуулна.
- 9.9. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиудыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, бэлэн байдлыг бий болгоно.
- 9.10. Сумын ИТХ, ЗДТГ-ын ажлын албаны автомашиныг шинэчилнэ.
- 9.11. Багийн Засаг дарга нарыг ажиллах нөхцөл, унаагаар хангана.
- 9.12. Сумын хэсгийн төлөөлөгчийг унаагаар хангана.

Боловсруулан: Баянгол сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчид

2020-06-19



3